

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/245/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн
Ерөнхий захирал: Т.Батсайхан
Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com
Аудитын менежер: Г.Оюунгэрэл
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com
Ахлах аудитор: Д.Алтайбаяр
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 01/190
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ХУНШАГАЙ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

1. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,104,967.96	58,513,414.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	18,190,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	18,190,000.00
3121	Төгрөг	00.00	18,190,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	18,190,000.00
33	АВЛАГА	1,397,034.96	21,440,162.96
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	20,043,128.00
335	Бусад авлага	1,397,034.96	1,397,034.96
3351	Байгууллагаас авах авлага	1,397,034.96	1,397,034.96
35	БАРАА МАТЕРИАЛ	12,707,933.00	18,883,251.88
354	Хангамжийн материал	12,707,933.00	18,883,251.88
35410	Бичиг хэргийн материал	3,285,680.00	7,465,591.88
35420	Аж ахуйн материал	8,418,946.00	8,935,276.00
35440	Түлш, шатах тослох материал	1,003,307.00	2,482,384.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	311,226,669.74	343,918,630.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	311,226,669.74	343,918,630.86
392	Биет хөрөнгө	233,276,669.74	290,993,630.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,359,284.00	5,359,284.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,787,243.83	-2,679,643.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,512,000.00	144,512,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,974,253.40	-107,125,369.15
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,623,897.71	258,017,647.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,522,465.20	-60,147,788.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,378,000.00	61,213,672.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,557,761.35	-12,427,024.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	788,176.02	4,690,762.02
39215	Хуримтлагдсан элэгдэл	-542,964.21	-419,909.61
393	Биет бус хөрөнгө	77,950,000.00	52,925,000.00
39301	Програм хангамж	250,000.00	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	77,950,000.00	52,925,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	325,331,637.70	402,432,045.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	325,331,637.70	402,432,045.70
51	Засгийн газрын хувь оролцоо	325,331,637.70	402,432,045.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	264,748,776.50	264,748,776.50
51101	Өмч: - төрийн	264,748,776.50	264,748,776.50
512	Хуримтлагдсан үр дүн	37,321,798.06	114,582,121.66
51210	Өмнөх үеийн үр дүн	-148,738,012.64	37,481,713.66
51220	Тайлант үеийн үр дүн	186,059,810.70	77,100,408.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,261,063.14	23,101,147.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	325,331,637.70	402,432,045.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,055,391,458.77	1,174,952,051.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	248,858,058.77	98,378,537.00
120	Нийтлэг татварын бус орлого	248,858,058.77	98,378,537.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	248,858,058.77	98,378,537.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	248,858,058.77	98,378,537.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	806,533,400.00	1,076,573,514.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	790,233,400.00	993,883,514.00

**Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	790,233,400.00	993,883,514.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,300,000.00	82,690,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,300,000.00	45,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	37,690,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	869,331,648.07	1,079,263,992.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	869,331,648.07	1,079,263,992.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,445,859.62	1,017,160,020.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,437,188.24	711,597,006.11
210101	Үндсэн цалин	428,545,387.97	446,498,438.11
210102	Нэмэгдэл	104,313,222.28	115,545,285.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,898,664.00	67,059,133.00
210104	Урамшуулал	47,679,913.99	82,494,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,017,158.80	91,151,067.30
210201	Тэтгэврийн даатгал	52,012,784.66	64,323,366.33
210202	Тэтгэмжийн даатгал	6,123,145.90	7,163,860.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,763,303.43	5,536,208.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,096,545.83	1,282,265.01
210205	Эрүүл мэндийн даатгал	11,021,378.98	12,845,367.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,269,111.00	39,116,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,100,000.00	794,343.00
210302	Түлш, халаалт	9,999,879.00	28,226,679.00
210303	Цэвэр, бохир ус	395,039.00	595,078.00
210304	Байрны түрээс	9,774,193.00	9,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,104,052.14	22,393,862.50
210401	Бичиг хэрэг	4,314,098.05	5,468,290.00
210402	Тээвэр, шатахуун	5,784,112.30	6,051,273.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,419,726.00	3,183,249.00
210404	Ном, хэвлэл	2,943,700.00	433,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210,000.00	494,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,865,673.79	6,180,650.00
210408	Бараа материал акталсны зардал	1,566,742.00	583,000.00
2105	Нормативт зардал	00.00	18,649,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	18,649,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,746,750.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	842,350.00	00.00
210604	Урсгал засвар	904,400.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,034,000.00	2,037,000.00
210702	Дотоод албан томилолт	2,034,000.00	2,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,672,759.01	47,079,903.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,092,103.21	41,297,187.66
210803	Даатгалын үйлчилгээ	304,350.00	304,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,400.00	154,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	400,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65,926,899.06	4,750,000.00
210807	Газрын төлбөр	158,775.00	158,775.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,672,231.74	15,105.12
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,164,840.43	85,135,580.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,673,809.16	5,553,920.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,491,031.27	79,581,660.68

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,885,788.45	62,103,972.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,034,500.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,034,500.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,220,802.00	36,143,386.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,220,900.00	3,181,550.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	29,879,714.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,999,902.00	3,082,122.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,630,486.45	25,960,586.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,630,486.45	25,960,586.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	186,059,810.70	95,688,058.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	18,587,650.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	18,587,650.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-18,587,650.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	186,059,810.70	77,100,408.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,748,776.50	-148,738,012.64	137,657,137.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	264,748,776.50	-148,738,012.64	137,657,137.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	1,614,690.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	186,059,810.70	186,059,810.70
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,748,776.50	37,321,798.06	325,331,637.70
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,748,776.50	37,321,798.06	325,331,637.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	264,748,776.50	37,321,798.06	325,331,637.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	77,100,408.00	77,100,408.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,748,776.50	114,582,121.66	402,432,045.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	806,533,400.00	1,076,573,514.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	806,533,400.00	1,076,573,514.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	790,233,400.00	993,883,514.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	790,233,400.00	993,883,514.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,300,000.00	82,690,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,300,000.00	45,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	37,690,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	782,784,400.00	1,005,011,842.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	782,784,400.00	1,005,011,842.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,819,511.55	922,864,741.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,437,188.24	711,597,006.11

**Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	428,545,387.97	446,498,438.11
210102	Нэмэгдэл	104,313,222.28	115,545,285.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,898,664.00	67,059,133.00
210104	Урамшуулал	47,679,913.99	82,494,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,017,158.80	91,151,067.30
210201	Тэтгэврийн даатгал	52,012,784.66	64,323,366.33
210202	Тэтгэмжийн даатгал	6,123,145.90	7,163,860.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,763,303.43	5,536,208.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,096,545.83	1,282,265.01
210205	Эрүүл мэндийн даатгал	11,021,378.98	12,845,367.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,269,111.00	39,116,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,100,000.00	794,343.00
210302	Түлш, халаалт	9,999,879.00	28,226,679.00
210303	Цэвэр, бохир ус	395,039.00	595,078.00
210304	Байрны түрээс	9,774,193.00	9,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,443,225.30	25,772,769.50
210401	Бичиг хэрэг	4,275,500.00	7,757,770.00
210402	Тээвэр, шатахуун	5,830,999.30	7,530,350.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,419,726.00	3,183,249.00
210404	Ном, хэвлэл	1,943,700.00	433,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	649,300.00	1,051,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,324,000.00	5,816,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,715,800.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,665,800.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,034,000.00	2,037,000.00
210702	Дотоод албан томилолт	2,034,000.00	2,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,738,028.21	47,870,798.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,756,503.21	42,103,187.66
210803	Даатгалын үйлчилгээ	304,350.00	304,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,400.00	154,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	400,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,750,000.00
210807	Газрын төлбөр	158,775.00	158,775.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,165,000.00	5,320,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,004,000.00	5,320,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,964,888.45	82,147,100.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,034,500.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,034,500.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,299,902.00	36,143,386.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,300,000.00	3,181,550.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	29,879,714.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,999,902.00	3,082,122.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,630,486.45	46,003,714.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,630,486.45	46,003,714.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,749,000.00	71,561,672.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,749,000.00	53,371,672.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,749,000.00	53,371,672.00

2200	Дотоод эх үүсвэрээр	23,749,000.00	53,371,672.00
223001	Бусад хөрөнгө	23,749,000.00	53,371,672.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-23,749,000.00	-53,371,672.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	18,190,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,190,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	993,883,600.0	967,922,927.57	25,960,672.43	97,39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	993,883,600.0	967,922,927.57	25,960,672.43	97,39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	957,739,600.0	931,779,541.6	25,960,058.4	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,667,600.0	711,597,006.1	16,070,593.9	97.8
210101	Үндсэн цалин	435,104,500.0	446,498,438.1	-11,393,938.1	102.6
210102	Нэмэгдэл	122,713,800.0	115,545,285.0	7,168,515.0	94.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,148,000.0	67,059,133.0	4,088,867.0	94.3
210104	Урамшуулал	98,701,300.0	82,494,150.0	16,207,150.0	83.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,163,100.0	91,151,067.3	7,012,032.7	92.9
210201	Тэтгэврийн даатгал	69,056,400.0	64,323,366.3	4,733,033.7	93.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,276,700.0	7,163,860.2	112,839.8	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,821,300.0	5,536,208.0	285,092.0	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,455,300.0	1,282,265.0	173,035.0	88.1
210205	Эрүүл мэндийн даатгал	14,553,400.0	12,845,367.7	1,708,032.3	88.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,495,700.0	39,116,100.0	2,379,600.0	94.3
210301	Гэрэл, цахилгаан	1,375,000.0	794,343.0	580,657.0	57.8
210302	Түлш, халаалт	30,030,000.0	28,226,679.0	1,803,321.0	94.0
210303	Цэвэр, бохир ус	590,700.0	595,078.0	-4,378.0	100.7
210304	Байрны түрээс	9,500,000.0	9,500,000.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,646,300.0	27,644,069.5	2,230.5	100.0
210401	Бичиг хэрэг	7,760,000.0	7,757,770.0	2,230.0	100.0

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	7,172,000.0	7,530,350.5	-358,350.5	105.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,979,000.0	3,183,249.0	795,751.0	80.0
210404	Ном, хэвлэл	433,400.0	433,400.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,051,900.0	1,051,900.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,250,000.0	7,687,400.0	-437,400.0	106.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.0	5,800,000.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	800,000.0	800,000.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,037,000.0	2,037,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	2,037,000.0	2,037,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,609,900.0	49,114,298.7	495,601.3	99.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,592,200.0	43,096,687.7	495,512.3	98.9
210803	Даатгалын үйлчилгээ	304,400.0	304,400.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,500.0	154,436.0	64.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.0	400,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	158,800.0	158,775.0	25.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,320,000.0	5,320,000.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,320,000.0	5,320,000.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,144,000.0	36,143,386.0	614.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,144,000.0	36,143,386.0	614.0	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,182,000.0	3,181,550.0	450.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,879,800.0	29,879,714.0	86.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,082,200.0	3,082,122.0	78.0	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	993,883,600.0	967,922,927.57	25,960,672.43	97,39
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	993,883,600.0	967,922,927.57	25,960,672.43	97,39
131001	Улсын төсвөөс санхүүжих	993,883,600.0	967,922,927.57	25,960,672.43	97,39
610002	Төсвөөс гадуур байгууллага	52.00	46.00	6.0	88.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	46.00	6.0	88.5
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	40.00	5.0	88.8
640003	Үйлчилгээний ажилтан	6.00	5.00	1.0	83.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,456,872.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,456,872.00
210602	Тавилга	39,456,872.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,043,128.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,043,128.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	20,043,128.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82,690,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,690,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,690,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	18,190,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,190,000.00

2. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийн тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлж аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс нь 2021 онд “Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн, эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
- Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх
- Төрийн захиргааны удирдлагаар хангах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх
- Татвар төлөгчдийн боловсролыг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль/шинэчилсэн найруулга/
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Нэмэгдэл цалин хөлс олгох тухай 2018 онд батлагдсан 382 дугаар тогтоолын 1,2,5,6,7 дугаар хавсралтуудад Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 151 тоот тогтоол
- Байгууллагын дотоод журам

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 869.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,079.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 16.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр тооцлоо. Энэ нь суурь үзүүлэлтийн дүн өмнөх оноос өссөнтэй холбоотой.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 402.4 сая төгрөг болж өмнөх оноос 77.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, дансны авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	18.2	18.2
Дансны авлага	1.4	21.4	20.0
Бараа материал	12.7	18.9	6.2
Үндсэн хөрөнгө	311.2	343.9	32.7
Биет бус хөрөнгө	78.0	52.9	-25.0
Нийт хөрөнгө	325.3	402.4	77.1
Эздийн өмч	264.7	264.7	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23.3	23.1	-0.2
Хуримтлагдсан үр дүн	37.3	114.6	77.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	325.3	402.4	77.1

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх оноос 18.2 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2017 оны 197-р тогтоолыг үндэслэн Татварын хэлтсийн даргын 2021 оны 12-р сарын 21-ний өдрийн А/57 тушаалаар “Ахмадын сан” байгуулсантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэл нь 20.0 төгрөгөөр өссөн байна. Аймгийн Засаг даргын 2021 оны А/633 захирамжаар 20.0 сая төгрөг нэмэлт санхүүжилтээр олгосон байна. Санхүүжилтийг зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст Төрийн санд төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийг авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18.9 сая төгрөг болж өмнөх оноос 6.2 сая төгрөгөөр өсөж бараа материалын нөөц бүрдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 343.9 сая төгрөг болж 32.7 сая төгрөгөөр өссөн нь:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1877 тоот албан бичгээр 20 ширхэг 46.5 сая төгрөгийн компьютер үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэн авсан.
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны хурлын тэмдэглэл, хэлтсийн даргын тушаалаар ажилчдаас өгсөн хандиваар 10.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил хүлээн авсан.

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 575 дугаар тогтоолоор 3.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, мөн шийдвэрээр 19.1 сая төгрөгийн тавилга эд хогшлыг Татварын ерөнхий газар-т балансаас балансад шилжүүлэн өгсөн.
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 нэр төрлийн 12 ширхэг хөрөнгийг 20.8 сая төгрөгөөр дахин үнэлж орлогод авсан.
- Нэмэлт санхүүжилтээс 53.3 сая төгрөгийн сургалтын танхим тохижуулах хөрөнгө худалдаж авсан.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 25.0 сая төгрөгөөр буурсан нь байгууллагын эзэмшилд байсан газрыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 575 дугаар тогтоолоор эрх шилжүүлэн данснаас хассан байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 114.6 сая төгрөг болж 77.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд дээд шатны төсвийн захирагчид 1,057.7 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн эрх захирагчид хүргүүлсэн байна. 2021 оны төсвийг Сангийн яамны 2021 оны 4-1/245 тоот албан бичгээр 993.9 сая төгрөгөөр баталж ирүүлсэн нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 224.2 сая төгрөгөөр өссөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зардал өмнөх оноос 209.9 сая төгрөгөөр буюу 24.1 хувиар өссөн байна. Өмнөх оны гүйцэтгэлээс материаллаг өөрчлөлттэй зардлыг харуулбал:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 17.3 хувь буюу нийт 105.2 сая төгрөг, үүнээс үндсэн цалин 17.9 сая, нэмэгдэл цалин 11.2 сая, унаа хоолны хөнгөлөлт 41.2 сая, урамшуулал 34.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил нэмэгдсэн нь 2021 оны төсөв нэмэгдэж батлагдсан, улс, орон нутгийн татварын төлөвлөгөө давж биелсэнтэй холбоотой байна. Тайлант оны төсөв өнгөрсөн оны гүйцэтгэлээс 224.2 сая төгрөгөөр өссөн байна. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл 16.1 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн орлого 17.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс 22.3 тэрбум төгрөг төвлөрүүлж 5.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн, улсын төсвийн орлого 7.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс 7.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 0.1 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Татварын төлөвлөгөөний биелэлттэй холбогдож байцаагч нар сарын орлогын төлөвлөгөөг биелүүлсэн тохиолдолд татварын хэлтсийн даргын тушаалаар 20 хувь хүртэл, ТЕГ-ын даргын шийдвэрээр 30 хувь хүртэл үр дүнгийн урамшуулал олгодог. Татварын улсын байцаагч нарын 2021 оны урамшууллыг Сангийн сайдын 2020 оны 168-р тушаал, ТЕГ-ын даргын 2021 оны А/111-р тушаал, аймгийн татварын хэлтсийн хөдөлмөрийн дотоод журам зэргийг үндэслэн Татварын хэлтсийн дарга сар бүр тушаал гаргаж урамшуулал олгодог байна.

Байр ашиглалтын зардал 17.9 нормын хувцасны зардал 18.6 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 30.1 сая төгрөгөөр өссөн байна. Байр ашиглалтын зардал нэмэгдсэн нь 2022 оны 9 сард 1489 м² талбайтай конторын шинэ барилга ашиглалтад орсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг харуулбал:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/448 тоот захирамжаар 20.0 сая, 2021 оны А/633 захирамжаар 20.0 сая, Мөрөн сумын засаг даргын 2021 оны А/199 тоот захирамжаар 5,0 сая, Улсын төсвөөс 19.5 сая төгрөг нийт 64.5 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн.

Нэмэлт санхүүжилтээс 44.4 сая төгрөгөөр сургалт мэдээллийн танхимын тавилга эд хогшил, хашаа, үндсэн санхүүжилтийн данснаас 18.1 сая төгрөгөөр ахмадын сан байгуулж нэмэлт санхүүжилтийн дансанд үлдээсэн, 20.0 сая төгрөгийг төрийн санд татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

Корона вирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан. 2021 оны төсвийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд үлдээж баталгаажуулсан байна. Энэ байгууллагын харилцах дансанд 18.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Тайлант онд Хөвсгөл аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар ур чадварын нэмэгдлийг илүү олгосон 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулан ажилласан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс нь 2021 онд нийт 2,195.3 сая төгрөгийн 136 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,191.5 сая төгрөгийн 135 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 1 мэдээлэл болох 3.8 сая төгрөгийн үнийн дүнтэй аудитын зөвлөмжийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 -ийг зөрчсөн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

Тайлант онд санхүүгийн тайлангаар тайлагнасан цалин 711.5 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварын тайланд тайлагнасан цалин 692.9 сая, нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалин 692.6 сая төгрөг байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 р тогтоол, Татварын хэлтсийн даргын 2021 оны А/51 тоот тушаалаар Ахмадын сан 18.1 сая төгрөгөөр байгуулсантай холбоотой байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын газар хийж 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх талаар анхаарч үзэх нь зүйтэй.

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн алдаа илэрснээс, 20.5 сая төгрөгийн алдааг залруулж, анхан шатны төлбөрийн баримт дутуу 4.6 сая төгрөг, шатахуун зарцуулалтын нормын хэтрэлттэй 0.2 сая төгрөг, шилэн дансны мэдээлэл хоцроосон 3.8 сая төгрөг нийт 8.6 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 20.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Татварын хуультай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хангамжийн материал 38.2 сая төгрөгийн худалдан авалтаас түүвэрлэн шалгахад дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтгүй 4.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4. “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4 заалтын дагуу дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтгүй худалдан авалт, борлуулалт хийхгүй байх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал “автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норматив”-ын дагуу автомашины шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас түүвэрлэн үзэхэд 0.2 сая төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах гэж заасан жишиг нормативтай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөн, хэрэгжүүлж ажиллах.

3. Шилэн дансны хууль тогтоомжтой тухай асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 2,195.3 сая төгрөгийн 136 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,191.5 сая төгрөгийн 135 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 1 мэдээлэл болох 3.8 сая төгрөгийн үнийн дүнтэй аудитын зөвлөмжийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”. Энэ хуулийн 6.4.5, 6.4.4, 6.2.5, 6.3.7, дахь заалтуудын хуулийн хугацааг хэрэгжүүлж ажиллах, шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс	4	29.1	1	20.5					3	8.6